

ХЭЗЭЭ Ч ГАНЦААРДАХГҮЙ

Хэрэв Итан хэн ч хажууд нь байхгүй үед бэртвэл яах вэ?



“Туслаарай!” гэж Итан хашхирав. Түүний нулимс хацрыг нь даган урслаа. Хүүхдүүд болон багш нар түүнд туслахаар гүйж ирэв.

“Юу болов?” гэж багш нь асуухад, “Би хөлөө хугалчихлаа!” гэв.

Энэ нь Итаны яс хугарч байгаа анхны тохиолдол байсангүй. Тэр ч бүү хэл хоёр, гурав дахь тохиолдол ч биш байв. Итан яс нь маш амархан хугардаг ясны сийрэгжилт өвчтэй байв. Үйрмэг дээр гишгэх, хэн нэгэнтэй шүргэлцэх зэрэг жижиг зүйлд хүртэл яс нь хугардаг байлаа.

Багш нь “Эцэг эх рүү чинь залгаж, эмч рүү чамайг аваачна. Бүх зүйл сайхан болно” гэлээ.

Итанд туслах хүмүүс байсанд тэр баяртай байв. Хөл нь маш их өвдсөн ч аюулгүй байна гэдгээ мэдэж байлаа.

Аав ээж нь сургууль дээр ирж Итаныг эмч рүү авч явав. Тэр хөлдөө цэнхэр өнгийн гипс тавиулж, гэртээ амрахаар явлаа.

Хөл нь хугарсан учир Итан орондоо ихэнх цагийг өнгөрүүлэх болов. Түүнд унших олон ном байлаа. Заримдаа хамт тоглохоор найзууд нь ирдэг байв. Тэгсэн ч гэсэн тэр уйддаг байлаа.

Нэгэн шөнө Итан сэрээд буцаж унтаж чадсангүй. Тэр амрах хэрэгтэй байсан ч санаа нь зовсоор байв. *Хэрэв би шөнө дунд хэн ч байхгүй үед аль нэг ясаа хугалчихвал яах вэ?* Итан тэр тухай бодоход л зүрх нь хүчтэй цохилж, айж сандрав.

Габриэл Шиозава
(Бодит түүхээс сэдэвлэв)

Энэ түүх АНУ-д болсон юм.

Итан савлуур дээр савлаж байлаа. Улам илүү өндөрт савласаар байв. Салхи түүнд нисэж буй мэт мэдрэмж төрүүлэв!

Удалгүй хонх дуугарлаа. Итан санаа алдаад, завсарлага дуусахыг хүсэхгүй байлаа.

Хүүхдүүд дотогш орохоор жагссан байв. Итан бага багаар савлахаа болив. Тэгээд тэр анги руугаа орохоор савлуураас буув.

Гэтэл Итан газарт хөлөө тавих үед хөл нь маш хүчтэй өвдөж, шороон дээр уналаа. Тэрээр босохыг хичээсэн ч хөл нь шатаж буй мэт үнэхээр их өвдөв.

“Аав аа!” гэж Итан хашхирав.

Аав нь Итаны өрөөнд гүйн орж ирээд, “Юу болоо вэ?” гэж асуулаа.

Итан “Би айж байна. Хэрэв би шөнө дунд надад туслах хэн ч байхгүй үед өөр нэг ясаа хугалчихвал яах вэ?” гэв.

Аав нь түүний хажууд орон дээр сууж, “Наадах чинь их аймаар бодол байна шүү. Бид хэдий болгоомжтой, аюулгүй байхыг хичээсэн ч муу зүйлс тохиолдоно. Гэсэн хэдий ч Тэнгэрлэг Эцэг чамайг харж хандаж байгаа” гэж тайвшруулав.

“Энэ нь Тэр үргэлж надтай хамт байна гэсэн үг үү?” гэж Итан асуув.

“Яг зөв!” гээд аав нь Итаныг зөөлөн тэврэв.

Итан аав нь түүнд ямар хурдан туслахаар ирснийг саналаа. Аав нь түүнд хайртай, түүнд

туслахыг үргэлж хүсдэг байв. Магадгүй Тэнгэрлэг Эцэг ч мөн адил байх.

Маргааш нь Итан *Найз* сэтгүүл дээр байсан судрыг уншив. “Зоригтой байгтун, мөн бүү эмээ, учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна, мөн та нарын дэргэд зогсож байх болно.”*

Итан судар унших үедээ аавтайгаа ярилцахад мэдэрсэн шигээ тайван, аюулгүй мэдрэмжийг мэдэрлээ. Ариун Сүнс түүнийг тайтгаруулж байгааг тэр мэдэж байв. Энэ нь түүнд яг л аавыгаа дахин тэвэрч байгаа юм шиг санагдав.

Миний яс дахиад хугарах л байх, гэхдээ би айх шаардлагагүй гэж Итан бодлоо. Тэр хэзээ ч ганцаардахгүй гэдгээ мэдсэн юм. ●

*Сургаал ба Гэрээ 68:6.



Та хэзээ Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэрсэн бэ?